

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

**Огноо:** 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр

**Тендерийн дугаар:** МРЦМ/202212191

1. Монголросцветмет” ТӨҮГ нь өөрийн эзэмшилд буй тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу “Монголросцветмет” ТӨҮГ-ын Булган, Төв, Хэнтий аймгуудын нутагт орших хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайнууд, үйлдвэр объектуудад Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хамт хийлгэх үйлчилгээ болно.
3. Зөвлөх үйлчилгээ нь дараах багцуудаас бүрдэнэ. Үүнд:
  - Багц 1: Урт сайр /XV-020523/, Галтын талбай /XV-020521/ - Төв, Заамар,
  - Багц 2: Бор-Өндөрийн далд уурхай /MV-000174/, Дулааны станц, Баяжуулах фабрик - Хэнтий, Бор-Өндөр
  - Багц 3: Цэцэг мандал /MV-020945/, Улаан-Уул /MV-007137/ - Төв, Заамар,
  - Багц 4: Туул голын гольдрил /MV-000175/ - Булган Бүрэгхангай, Төв Заамар,
  - Багц 5: Төмрийн хорголжингийн үйлдвэр, Баргилт /XV-021822/ - Хэнтий, Бор-ӨндөрМэдүүлгээ ирүүлэх зөвлөх хуулийн этгээд нь дээрх 5 багцаас зөвхөн 1 багцад оролцох боломжтой.
4. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
  - Байгууллагын ерөнхий танилцуулга,
  - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар,
  - Тусгай зөвшөөрөл /Тендер зарласан өдрөөр хүчинтэй байх, эсвэл тендер зарлахаас өмнө БОАЖЯ-нд тусгай зөвшөөрлөө сунгуулах хүсэлт өгсөн байх/
  - Сүүлийн 3 жилд уул уурхай, баяжуулах үйлдвэрийн төсөлд БОНБНҮ хийж байсан туршлагын мэдээлэл /гэрээ, гэрээ дүгнэсэн акт/,
  - Татварын өргүй тухай тодорхойлолт зэргийг ирүүлнэ.
  - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2022 оны 03 дугаар сарын 29–ний өдрийн 09 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 09 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ